



Research article

Алшаа Агваандандар лхаарамбын “Хүмүүний номын баяр хурим” зохиолын орчуулгуудын харьцуулсан судалгаа

Мөнхбатын Төрмандах¹ , Пүрэвдоржийн Эрдэнэтуяа*² 

¹Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит Монголын Бурханы шашны их сургуулийн Хэл шинжлэл, уран зохиолын тэнхимийн багш, Монгол Улсын Боловсролын их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн докторант, Улаанбаатар, Монгол Улс

²Монгол Улсын Боловсролын их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Монгол хэлний тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор. Улаанбаатар, Монгол Улс

ARTICLE INFO

History.

Received: 28 March, 2026

Revised: 12 May, 2026

Published: 05 June, 2026

Түлхүүр үг:

Төвөд хэлт сургаалын зохиол,
Алшаа Агваандандар
лхаарамба, уламжлалт
орчуулга, нэрийн арван бага,
үгчлэн орчуулах арга,
аллитераци

ABSTRACT

Монголын нэрт эрдэмтэн Алшаа Агваандандар лхаарамбын туурвисан “Суртгаал хүмүүний номын баяр хурим” (Tib: blsab bya mi chos dga' ston zhes bya ba bzhugs so) хэмээх зохиол нь төвөд хэлээр бичигдсэн бөгөөд төвөд бичиг номын өвөрмөц хэл найруулга, буддын гүн ухааны ойлголтуудын нэр томъёо, илт өгүүлэх буюу ёгт нэр, маш хатуу "айлын үг" гэдэг эгэл хар үг хэллэг зэргийг хослуулан сүлжсэн онцлогтой орчуулахад нэн төвөгтэй бүтээлийн нэг юм. Гэвч тус зохиолыг Их хүрэн уламжлалт нэр орчуулгын хичээлд судалж ирсэн тул түүний олон орчуулга бидэнд уламжлагдан ирсэн талаар эрдэмтэд мэдээлсээр иржээ. Бид энэхүү судалгааны ажлаар эдгээр орчуулгуудыг олж цуглуулах, мэдээллийг нэгтгэх, мөн зарим орчуулгын мэдээг бүрдүүлэхийг зорьсон ба түүнчлэн олдсон орчуулгуудын бичиглэлийн шинж чанар, онцлогийг тодорхой хэмжээнд тусган авч үзэв. Судалгааны үр дүнд арван дөрвөн орчуулгыг олж бүрдүүлсэн ба нэмэлтээр таван орчуулгын талаарх мэдээг цуглуулав. Эдгээр орчуулгуудыг ажиглахад монгол үгийг төвөд үсгээр галиглан бичсэн, монгол шүлгийн толгой холбох аргыг хэрэглэсэн, уламжлалт үгчилсэн орчуулгын аргыг хэрэглэсэн, илт өгүүлэх нэр болон хүндэтгэлийн нэр зэргийг орчуулсан зарим онцлог ажиглагдаж байна. Цаашид холбогдох бусад орчуулгын мэдээ, баримтыг нэмэгдүүлэн цуглуулж, тэдгээрийг харьцуулан шинжлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

© 2026, Author(s). This is an open access article under the CC BY-04 license (<https://creativecommons.org/licenses/by/4.0/deed.en>)

1. Удиртгал

Эртний энэтхэгийн Бурханы шашны уудалж баршгүй уран зохиолын соёлын өв, цаст төвөдийн элдэв сонин түүх зохиолуудыг монголын эрдэмтэн мэргэд гүүш нар орчуулах, дахин найруулан зохиох, төвөд монгол хоёр хэлээр зохион бичих зэргээр өөриймшүүлэн, монгол хүний сэтгэхүйд хүлээн авахуйц болгон монгол уран зохиолынхоо хөгжлийг урагш ахиулсаар иржээ. Энэхүү хүнд бэрхшээлтэй мөртөө нэр хүндтэй үүргийг ихэвчлэн Бурханы шашны үнэнч зүтгэлтэн болсон монгол лам эрдэмтэд биелүүлсэн юм.

Цаст төвөдийн орныг зорин Бурханы шашны эрдэм мэдлэгийн дээдэд хүрч, их, бага ухаанд нэвтэрсэн мэргэд олон гарч тэдгээрийн дотроос төвөд хэлээрээ зохиол бүтээлээ туурвисан монгол эрдэмтдийг монголчууд байтугай төвөдийн мэргэд хүртэл үзэн судалж, үнэлэлт дүгнэлт гарган гайхан магтдагийн нэгэн төлөөлөгч бол Алшаа лхаарамба, Дандар лхаарамба, Лхадан Монлам равжамба Агваандандар зэрэг нэрээр олноо алдаршсан Алшаагийн Агваандандар лхаарамба (1759-1840) юм. Тэрээр нэгэн насаа монгол, төвөдийн ард түмний соёл гэгээрэлд зориулсан, буддын

гарамгай гүн ухаантан, хэл шинжээч, яруу найргийн онолч, шашны зүтгэлтэн хүн тул зохиол бүтээл нь монгол орноо төдийгүй төвөдийн мэргэд ч үзэн, судалж ирсэн билээ.

Их хүрээний уламжлалт сургалтад нэр орчуулга буюу төвөд хэлнээс монгол хэлэнд орчуулан сургахад “Нэрийн арван бага” хэмээн нэрлэж ирсэн сургаалын зохиолуудыг судалдаг бөгөөд багшаас шавьд амаар уламжлан заадаг байжээ. Эдгээр зохиолуудын дотроос Алшаа лхаарамба Агваандандарын “Суртгаал хүмүүний номын баяр хурим” (Tib: blsab bya mi chos dga’ ston zhes bya ba bzhugs so) хэмээх төвөд хэлээр бичсэн энэ зохиол нь маш хатуу “айлын үг” гэдэг эгэл хар үг, төвөд бичиг номын өвөрмөц хэллэг буюу ухааж ойлгоход маш бэрх шашин номын үг илэрхийлэл, илт өгүүлэх хэмээх ёгт нэрийн зүйл, буддын гүн ухааны нэр томъёог холин сүлж бичсэн зохиол юм.

Энэхүү зохиол нь туурвин бичих аргын хувьд тухайн үеийн хуучирсан болон хүнд хэцүү ховор үгсийг нэгтгэн яруу найраг, эвсүүлэн найруулах арга зэргийг ашиглан дөрвөн мөртөөр зуун шүлэг болгон жигдэлсэн сургаалын зохиолын төрөл зүйлд хамаарах зохиол байна.

2. Судлагдсан байдлын тойм

Алшаа Агваандандар лхаарамбын намтар, зохиол бүтээлийн судалгаа харьцангуй эрт буюу Орос Буриадын дорно дахин судлаач Г.Ц.Цебыков 1914 онд богд Зонхавын зохиосон “Ламримчэнбо” зохиолыг орос хэлээр орчуулан, эрдэм шинжилгээний дэлгэрэнгүй удиртгал тайлбартайгаар хэвлүүлсний удиртгал хэсэгт “Агваандандар хэл шинжлэл, философиор чухал үнэтэй бүтээл олныг туурвисан” хэмээн тэмдэглэжээ. Харин монголд 1959 онд Олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар их хуралд МБШТөв-Гандантэгчэнлин хийдийн XXV хамба номун хан, номч мэргэн гавж Самаагийн Гомбожав “Монголчуудын төвөд хэлээр зохиосон зохиолын зүйл” хэмээх илтгэлдээ монголын буддын мэдлэг ухааны түүхийн хуудаснаа төвөд хэлээр нэгээс гучин хоёр боть хүртэл ном зохиол бүтээн туурвисан 208 эрдэмтэн ламыг танилцуулсан ба тус өгүүллийнхээ дагалдуулал болгож хэвлүүлсэн бүртгэлийн долоодугаарт “Агваандандар лхаарамба Алшаа хошуу, арван наймдугаар зууны үеийн хүн, бүх зохиол нь хоёр боть, судар, тарнийн тайлбар, дуун ухааны онол зэрэг. Гүмбүмд бартай” (Гомбожав, 1961, р. 26) хэмээн олон нийтэд мэдээлжээ. Үүнээс Алшаа Агваандандар лхаарамбын зохиол бүтээлийн судалгаа эрчимжиж олон эрдэмтэд үнэлэлт дүгнэлт гаргасаар иржээ. Дурдвал Л.Хүрэлбаатар “Төвөдийн мэргэдийн төвөд хэлээр найруулж бичих, зохиох туурвихын гайхамшигт үлгэрийг үзүүлсэн Алшаа лхаарамба Агваандандар...” (1992, р. 8) хэмээн тодорхойлсон байна.

Алшаа Агваандандар лхаарамбын олон талт зохиол бүтээлийн судалгааг нэг бүрчлэн дурдахад маш олон хуудас болох тул онцгойлон Өвөр Монголын эрдэмтэн Г.Цогтын 1999 онд эмхэтгэн гаргасан “Алшаа Агваандандарын судалгааны өгүүллийн чуулган” бүтээлийг дурдах нь зүй ёсны хэрэг биз ээ. Энэ зохиол нь нийт 3 дэвтэр, үүний 1-р дэвтэр нь ерөнхийлсөн шинжтэй 36 өгүүлэл бүхий 374 хуудас, 2-р дэвтэр нь Хэлний чимэг зохиолд нь голлосон 21 өгүүлэл бүхий 354 хуудас, 3-р дэвтэрт нь Зохист аялгууны чимгээр бичигдсэн хоёр өгүүллийг нь голлосон Онол өгүүлэхүйн 17 зохиол бүхий 360 хуудастай ажээ. Гэвч эдгээр судалгааны өгүүлэлд нэгэн санааг давтсан агуулга буй боловч Цай Юнь хэмээх судлаачийн бичсэн “Сургаал хүний номын баяр хуримын төвөд монгол эхийг дөхөм харьцуулах нь” хэмээх өгүүлэл анхаарал татаж байна. Үүний дараа Г.Цогт голлон найруулсан “Алшаа лхаарамба Агваандандарын зохиолын чуулган” 6 боть сүмбүмийг 2014 онд Өвөр Монголд хэвлэснийг онцгойлон дурдъя. Тус бүтээл нь Агваандандар лхаарамбын бүрэн зохиолыг монгол хэлэнд орчуулан гаргасан байна.

Агваандандар лхаарамбын “Хүмүүний номын баяр хурим” бүтээлийн олон орчуулга буй талаар Л.Хүрэлбаатар, Агваанчойдор, Цай Юнь зэрэг эрдэмтэд олон дурдсан ба тэдгээрийг дараа 2014 онд Г.Цогт голлон найруулсан “Алшаа лхаарамба Агваандандарын зохиолын чуулган” 6 боть бүтээлийн 6-р ботид уг бүтээлийн арван нэгэн орчуулгыг мөр тус бүрээр нь харгалдуулан, монгол бичгээр хэвлүүлсэн байна. Гэвч эдгээр орчуулгуудыг харьцуулсан өгүүлэл, илтгэл хараахан

гараагүй бөгөөд уг бүтээлд орсон орчуулгуудаас гадна хэд хэдэн орчуулгын мэдээ баримтууд байсаар байна.

3. Судалгааны арга, хэрэглэгдэхүүн

Бид энэхүү судалгааны ажилдаа “Хүмүүний номын баяр хурим” зохиолын орчуулгатай холбоотой мэдээ баримтуудыг цуглуулан нэгтгэх хээрийн судалгааны арга ба зарим олдсон орчуулгуудын ерөнхий шинж чанарыг нь тодорхойлох зүйлчлэлийн арга, үгийг оноосон байдлаар нь зөрүүтэй, ижил талыг нь харьцуулж үзэх аргыг голчлон ашигласан болно.

4. Үндсэн хэсэг

"Хүмүүний номын баяр хурим" хэмээх зохиол нь яруу найраг, эвсүүлэн найруулах арга зэргийг ашиглан 100 шүлэг буюу 400 мөр, нэг мөрөнд 9 үе (тө: tseg bar)-ээр жигдэлсэн шүлэглэсэн сургаалын зохиол ба энэхүү зохиол нь бидний тооцоолж гаргаснаар төгсгөлийн үгтэйгээ нийлээд 3916 үеэс бүрдэх нийт давхардсан тоогоор 2557, давхардаагүй тоогоор 2000 орчим үгтэй байна. (Төрмандх, 2025, р. 131)

Дээд Монголын нэрт эрдэмтэн, төвөдөч Агваанчойдар өөрийн судалгааны бүтээлдээ Алшаа Агваандандарын зохиолын онцлогийг тодорхойлон дүгнэхдээ түүний бүтээлүүдийг монгол хэлний орчуулахад бэрх талаар онцлон тэмдэглэсэн байдаг. Тэрээр *“Монголд Агваандандарын зохиолыг орчуулахаар хүн байхгүй, Яагаад гэвэл Агваандандарын зохиол хуучин төвөд хэлний хатуу үг, төвөд газрын олон хар үгнүүдийг шинжилж судлаад, тэднийг сайхан найруулж зохиосон байдаг. Бас төвөдийн нэг үгэнд хэдэн янзын утга бий. Түүнийг цөм гаргаж ирэхээр орчуулахад хүчир юм. Агваандандарын бичсэн "Хүмүүний номын баяр хурим" гэдэг судрын монгол орчуулга олон байдаг. Гэвч Халхын Цэрэн гэрганы орчуулга тайлбар бол хамгийн сайн нь юм”* (2009, р. 81) хэмээн тэмдэглэсэн байна. Үүнээс үзвэл Агваандандар лхаарамбын зохиолууд нь төвөд хэлний хуучин нэр томъёо, олон давхар утга бүхий үг нэр томъёо, нутгийн өнгө аяс бүхий хэллэгүүдийг өргөн ашиглаж, тэдгээрийн уран нарийн найруулгаар нэгтгэн зохиолдоо шингээсэн байдаг. Тиймээс түүний зохиол бүтээлийг орчуулахад орчуулагч тухайн үгийн бүх боломжит утгыг нягтлан судалж, зөв оноох шаардлагатай болдог. Нэг үг хэд хэдэн утгатай байх тохиолдолд тухайн өгүүлбэрийн утга, эх зохиолын агуулгын хүрээнд аль утгыг сонгох нь маш нарийн мэдрэмж, гүн мэдлэг шаардсан ажил юм.

Гэвч ӨМӨЗО-ны эрдэмтэн Г.Цогт 2014 онд “Алшаа лхаарамба Агваандандарын зохиолын чуулган” хэмээх зургаан боть зохиолыг голлон найруулж Агваандандар лхаарамбын бүрэн зохиолын монгол хэлэнд орчуулж хэвлэсэн байна. Энэхүү бүтээлийн зургаадугаар ботид “Хүмүүний номын баяр хурим” зохиолын арван нэгэн орчуулгыг төвөд эхийн хамт мөр, шад бүрээр нь харгалдуулан эмхэтгэсэн байна. Энэ төрлийн эмхэтгэл нь зөвхөн орчуулгын үр дүнг нэгтгэсэн төдий бус, харин харьцуулсан судалгааны үнэт хэрэглэгдэхүүн болжээ. Өөрөөр хэлбэл, нэг эх зохиолыг олон өөр орчуулгатай харьцуулснаар тухайн үгийн олон салаа утга, орчуулагч бүрийн арга барил, ойлголтын ялгаа, хэл найруулгын онцлог зэргийг нарийвчлан судлах боломж бүрддэг. Иймд уг бүтээл нь Агваандандарын зохиолын хэл найруулга, үгийн сан, утга зүйн олон давхар шинжийг тайлахад чухал ач холбогдолтой бөгөөд цаашдын орчуулга, хэл шинжлэлийн судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулжээ. Тус ботид дараах орчуулгууд багтсан ба үүнд:

1. Цэрэнгийн орчуулсан “Хүмүүний номын баяр хурим хэмээх сургаал оршвой” (kümün-ü nom-un bayar qurim kemekü surḡal orusibai) гэх гарчигтай орчуулга;
2. Пэрэнлэйн орчуулсан “Хүмүүний номын баясгалангийн хурим хэмээгдэх суртал оршвой” (kümün-ü nom-un bayasqulang-un qurim kemegdekü surtal orusibai) гэх гарчигтай орчуулга;

3. ӨМӨЗО-ы Багшийн Их сургуульд хадгалагдаж буй орчуулга “Хүмүүн номын баяр хурим” (kümün nom-un bayar qurim) гэх гарчигтай орчуулга;
4. Үндэстний клубт хадгалагдаж буй орчуулга “Хүмүүний ёсны баяр хурим” (kümün-ü yosun-u bayar qurim) гэх гарчигтай орчуулга;
5. Агваанчойдорын орчуулсан “Хүмүүний номын баярын хурим хэмээх судар оршвой” (kümün-ü nom-un bayar-un qurim kemekü sudur orusibai) гэх гарчигтай орчуулга;
6. Чоймболын орчуулсан “Хүмүүний номын баяр хурим хэмээх сургаал оршвой” (kümün-ü nom-un bayar qurim kemekü surḡal orusibai) гэх гарчигтай орчуулга;
7. Л.Хүрэлбаатарын (1992) “Алтан хүрдэн” зохиол дахь уламжлалт орчуулга гэх тодотголтой судрын аман орчуулгын бичигт буулгасан хувилбар болох “Хүний номын баяр хурим” гэх орчуулга (орчуулагч тодорхойгүй);
8. Лувсансамданы орчуулсан “Номын хүмүүний баяр хурим хэмээгдэх сургаал оршвой” (nom-un kümün-ü bayar qurim kemegdekü surḡal orusibai) гэх гарчигтай орчуулга;
9. Донровжамцын орчуулсан “Хүмүүний номын баяр хурим хэмээгдэх сургаал оршвой” (kümün-ü nom-un bayar qurim kemegdekü surḡal orusibai) гэх гарчигтай орчуулга;
10. Донровжамцын орчуулсан “Хүмүүний номын баяр хурим хэмээгдэх сургаал оршвой” (kümün-ü nom-un bayar qurim kemegdekü surḡal orusibai) гэх гарчигтай орчуулга;
11. М.С.Өлзийн орчуулсан “Сургаал хүмүүн номын баяр хурим” (surḡal kümün nom-un bayar qurim) гэх нэртэй орчуулгуудыг эмхэтгэн монгол бичгээр хэвлүүлсэн байна.

Үүний дээр нэмж бидэнд дараах гурван орчуулга хуулбар, эх хувиараа олдоод байна. Үүнд:

12. **Гарчиг:** “Суртгаал хүмүүнийг засагч баясахын хурим хэмээн үйлдэн оршвой” (Tib: @#/ /bslab bya mi chos dga’ ston ces bya ba bzugs so/ /@#/ /sor thu kal khu mung ni gi dza sag che pa yi sa ha’i hU rim khe ming u li ting ‘or shu pas),
Хуудасны хэмжээ: 28x8.5, (25.5x7) см
Бэх: хар бэх
Бичгийн төлөв: гар бичмэл
Хуудасны тоо: 1a-19b хуудас бүтэн,
Бичвэр: 8 мөр гар бичмэл эхээс 4 нь “Хүмүүний номын баяр хурим” зохиолын төвөд эх, 4 нь төвөд эхийн доор төвөд үсгээр монгол үгийн галиглан бичсэн хадмал орчуулга.
Лавлагаа: Хувилж авсан хуулбар эх нь зохиогчийн хувийн цуглуулгад хадгалагдаж байна. Үндсэн эх хувь нь хаана байгаа нь тодорхойгүй байна.
13. **Гарчиг:** @#/ /bslab bya mi chos dga’ ston ces bya ba bzugs so/ / “Сурган үйлдэх хүмүүний номын баясгалангийн хурим хэмээн үйлдэгч оршвой” (surḡan üiledkü kümün-ü nom-un bayasḡulang-yin qurim kemen üilüldegci orusibai)
Хуудасны хэмжээ: 34x9.5, (30x8) см
Бэх: хар бэх
Бичгийн төлөв: гар бичмэл
Хуудасны тоо: 1a-21b хуудас бүтэн,
Бичвэр: 6 мөр гар бичмэл эхээс 3 нь “Хүмүүний номын баяр хурим” зохиолын төвөд эх, 3 нь төвөд эхийн дор монгол хэлээр монгол бичгээр зүүж бичсэн хадмал орчуулга.

Лавлагаа: Хувилж авсан хуулбар эх нь зохиогчийн хувийн цуглуулгад хадгалагдаж байна. Үндсэн эх хувь нь хаана байгаа нь тодорхойгүй байна.

14. **Гарчиг:** @#/ _/bslab bya mi chos dga' ston ces bya ba bzhugs so/ _/ (гарчгийн орчуулга байхгүй)

Бэх: Цэнхэр бэх

Бичгийн төлөв: гар бичмэл

Хуудасны тоо: 1-23 хуудас бүтэн,

Бичвэр: 18 мөр гар бичмэл эхээс 9 нь “Хүмүүний номын баяр хурим” зохиолын төвөд эх, 9 нь төвөд эхийн дор монгол хэлээр кирилл бичгээр зүүж бичсэн хадмал орчуулга.

Лавлагаа: МБШИС-ийн багш, Ph.D доктор Ш.Сонинбаярын аман орчуулгыг Ph.D доктор Д.Даваасүрэн тэмдэглэл болгон хөтөлснөөр Д.Даваасүрэнгийн хувийн номын санд хадгалагдаж байна. Үүний хувилж авсан хуулбар эх нь зохиогчийн хувийн цуглуулгад хадгалагдаж байна.

Үүний дээр “Хүмүүний номын баяр хурим” зохиолын орчуулгатай холбоотой дараах мэдээ бидэнд олдоод байна. Үүнд:

1. Буриадын Жимба хамбын төвөд хэлээр зохиосон буриад лам нарын бичсэн номын каталог дунд “Алшаа Дандар лхаарамбын зохиосон суртгаал хүмүүний номын баяр хурим монгол хэлэнд орчуулсан” (Tib: a lag sha bstan dar lha rams bas mdzad pa'i bslab bya mi chos dga' ston sog skad du sgyur ba) хэмээх гарчиг бүхий орчуулга,
2. Хэл зохиолын хүрээлэнгийн ахмад эрдэмтэн Р.Отгонбаатарын хувийн цуглуулгад Арвай хээрийн Тарган бандида Цэвэлванчигдоржийн орчуулж Арвай хээрийн бард бүтээсэн 19 хуудас бүхий орчуулга
3. Доктор, профессор Л.Хүрэлбаатарын хувийн цуглуулгад түүний 1965 онд Хотгойдын Дондивын Жалцав хэмээх номч гэвшээс дуудуулж хэлүүлж авсан судрын аман орчуулга,
4. Доктор, профессор Л.Хүрэлбаатарын хувийн цуглуулгад түүний 1980 онд Бирваа бэйсийн Очир тойноос хэлүүлж авсан судрын аман орчуулга,
5. Доктор, профессор Л.Хүрэлбаатарын хувийн цуглуулгад түүний 1992 онд Гандантэгчэнлин хийдийн хансүрва Дамдинсүрэн ламтнаас дуу хураагуурт бичүүлж авсан судрын аман орчуулга (Хүрэлбаатар, 2002, р. 130) байгаа мэдээ буй боловч бид хараахан үзээгүй болно.

“Орчуулга гэдэг нь нэг хэлний бүтэц, утга, найруулгыг нөгөө хэлнийхээр сольж тухайн зохиолыг дахин боловсруулах үйл явц” (Мөнхцэцэг, 2022, р. 107) бөгөөд бидэнд олдоод буй арван дөрвөн орчуулга нь өөр өөрсдийн гэсэн тусгай бүтэц, утга, найруулгын онцлогтой. Тиймээс эдгээр орчуулгуудын ерөнхий шинж чанарыг тодорхойлох хэрэгтэй. “Орчуулгын аргыг орчуулга судлаачид олон янзаар ангилсан байдаг ч хамгийн сонгодог ангилал нь дүйлгэн орчуулах, үгчлэн орчуулах, утгачлан орчуулах, тайлбарлан орчуулах, зээлдэх гэсэн арга юм.” (Мөнхцэцэг, 2022, р. 123) Үүнээс Монголчууд түүхийн олон зуун жилийн төвд хэлнээс хэлнээс маш их номыг өөрийн хэлэнд орчуулсан юм. Үүний дотроос яруу найргийн зохиолыг орчуулах гурван үндсэн арга боловсорч тогтсон байна. Энэ гурван аргын нэг нь үсэгчлэн орчуулах, нөгөө нь утгачлан орчуулах арга, гарав дахь нь дуурайлган зохиох арга болно. (Хүрэлбаатар, 1995, р. 120)

Ингээд бид энэхүү судалгааны ажилдаа дээрх бидэнд олдоод буй арван дөрвөн орчуулгын ерөнхий шинж чанарыг нь тодорхойлоод, үгийг оноосон байдлаар нь зөрүүтэй, ижил талыг нь харьцуулж үзүүлэхийг хичээе.

Монгол үсгийг төвөд үсгээр галиглан хөрвүүлсэн нь

Орчуулгуудаас 12-р орчуулгад монгол үгийг төвөд үсгээр галиглан орчуулсан нь сонирхол татаж байна. Мөн Г.Цогт голлон найруулсан 2014 оны “Алшаа лхаарамба Агваандандарын зохиолын чуулган” зургаадугаар ботийн төгсгөлийн хавсралт буюу 2329-р талд орчуулгуудын нүүр хуудасны зургийг хавсаргасан ба уг хавсралтаас ажиглавал 1 болон 5-р орчуулгуудад мөн монгол үгийг төвөд үсгээр галиглан бичсэн буй боловч уг хавсралтад зөвхөн нүүр хуудсыг хавсарсан ба уг ботид монгол бичигт буулган оруулсан тул уг орчуулгыг эх хувиар нь үзэх боломж бидэнд олдсонгүй. Жишээ нь:

Tib: zha ‘on ‘theng skur sogs kyi lad mo spong / /
shu thor sha bkra sbyi cer zhes mi ‘bod/ /
kha ‘cham byas te gzhan la ‘phyas mi ‘dogs/ /
sdum mtses rnam la shub pus smod mi bya/ / (85)

12-р орч. tha hir/ _tu li/ _tha than has/ _bu gi ther/ _ther ku thin ni gi/ _il gil hi gi/ _thib chi/
nyi so/ _thar hag sang/ _ma ha ne/ _‘iring thig sing/ _ho ci ka ra/ _hi mi’ing/ _bu/ _to ta
ug/ _tha’ tsha gyi/ _‘us lid hu/ _bu gi te/ _bo sad/ _tur/ _son cil hos/ _bu tsus
gir/ _a’ li/ _nyi kvo ta/ _tur/ _shi bi nyu hus/ _biri/ _zho la ci/ _ya kvo/ _‘us lid hi bi/ (16a) гэж
орчуулав.

Мөн “Сургаал хүмүүний номын баяр хурим хэмээгдэх түүвэр нэр оршвой” (Tib: @#/ _/bslab
bya mi chos dga’ ston ces bya ba btus ming bzhugs so/ _/) хэмээх гар бичмэл сударт ихэнх үгсийг төвөд
үсгээр галиглан бичсэн монгол орчуулгыг бичсэн ба зарим үгсийг төвөдөөр тайлбар хийсэн нь
харагдана.

Төвөд үсгээр, монгол үгийг галиглах тусгай дүрэм, журам байгаагүй ба бичээчийн өөрийн
тогтоосон дүрмийн дагуу бичигддэг байсан тухай доктор Д.Ганболд “Төвд үсгээр, монгол хэлний
үгсийг галиглах нэгдсэн тогтолцоо үгүй бололтой бөгөөд тухайн бичээчийн дур зоргоор хийгдэж
байсныг батална.” (2023, р. 1) хэмээн дүгнэсэн байна.

1. Монгол шүлгийн толгой холбох онцлогт зохицуулан орчуулсан нь

Монгол шүлэгт хөг аялгуу чухал үүрэгтэй бөгөөд шүлгийн толгой холбоц Alliteration буюу
Аллитераци бол монгол шүлгийн гол шинж юм. “Монгол шүлгийн гол онцлог бол толгой холбох
явдал” гэж Оросын монгол судлаач А.Позднеев үзжээ. Мөн Чехийн монгол судлаач П.Попуха
“Монгол шүлгийн гадаад гол шинж нь гэвэл толгой холбож ая нийлүүлэх явдал юм. Ийм шинж
монгол шүлэглэлд эрт дээр үеэс тодорчээ.” гэж бичжээ. Мөн монголын зохиолч нар ч үүнтэй ижил
дүгнэлт хийсэн байдаг, тухайлбал Л.Түдэв “Монгол шүлэг гэж хармагц эсвэл сонсмогц таних
тэмдэг нь ‘толгой холбоц’ юм” гэсэн бол зохиолч, орчуулагч Н.Жамбалсүрэн “Монгол шүлгийн
толгой холбох нь европ шүлгийн сүүл холбохтой адил юм” хэмээн бичсэн. (Долгорсүрэн, 2022, р.
90)

Тус зохиолын зарим орчуулгад нэр илэрхийллийг оноох дүйлгэх арга зарчмын хувьд
үндэстний өвөрмөц онцлогийг тодруулж, монгол шүлгийн толгой холбох онцлогт зохицуулан
орчуулсан байх бөгөөд энэ нь шашин номын санаанаас нь нэлээд иргэншүүлж, эгэлжүүлсэн өнгө
аястай болжээ. Гэвч энэ нь цаагуураа уг сургаалыг жирийн ард иргэдэд хүргэх гэсэн зохиогчийн
зорилго чиглэлийг тод томруун харуулж чадсан байна.

Жишээ нь:

Tib: sa rim ‘ded dam ‘u lag rgyug mi dgos/ /
phyugs med pas ni rdzi po ‘tshol ci dgos/ /
ba lang lhas kyi grum ral ‘chos don med/ /
khal ma zhon rta chad kyis dogs pa dben/ / (35)

6-р орч. örtege ulay-a-yin damjiy-un kurgögül-dü güyühü-yin ucir-ču ügei
ürejiltü mal-un qota ni qayaydaysan-iyar aduyulayci-yi erikü cü ügei
üker-ün qasiy-a-yin emterejü seteregsen-i selbikü kereg cü ügei

unuly-a acilya ügeyidejü qoyusurayad kül yabuylaqu sejig cü ügei (Цогт, 2014, pp. 2056-2059)

7-р орч. Алба өртөөнд хөөгдөх, улаа нэхэх хэрэг үгүй

Арчлах мал үгүй тул сүрэг бүл ч эрэхийн хэрэг үгүй

Амины үхрийн хашаа хэмхэрснийг засах хэрэг үгүй

Ачилга уналга эцэж турна гэх сэжиг үгүй (Хүрэлбаатар, 1992, р. 26)

гэж орчуулжээ. 6-р орчуулгад бадаг тус бүр “А” үсгээр, 7-р орчуулгад Монгол бичгээр бичигдсэн тул “Тэдэс”-ээр толгой холбосноор барахгүй хоёр орчуулга төгсгөлийн хэсгийг хүртэл “үгүй” гэж сүүл холбосон харагдаж байна. Энэ орчуулгад үгийн нэмэгдэл хорогдол ихтэй тул үгийг танихад тохиромжгүй ч уншин сонирхогчдод цэвэр монгол хэлээр бичсэн шүлгийг уншсан мэт сэтгэгдэл өгч утгыг бүрэн гүйцэд гаргаж чадсан байна.

Ингэж уг эхэд байхгүй шинэ шинэ үг хэллэгийг нэмж орчуулах нь зохиолын хүнд хүрэх, шүлгийн аяс айзам, хэмжээ хэмнэлийн байдлыг тааруулахад тустай хэрнээ шүлгийн агуулга, үндсэн санааг огт гажуудуулсангүйгээр барахгүй, харин ухахад санаанд бууцтай, сонсоход чихэнд нийцтэй болсон байдгийг судлаачид тэмдэглэсэн байдаг (Хүрэлбаатар, 2002, р. 142).

2. Уламжлалт үгчлэн орчуулах зарчмыг баримтлан орчуулсан нь

Дээрх орчуулгуудад задгай сайхан толгой холбосны дээр үгийг чөлөөтэй сонгон, илэрхийлэн гаргахын аль илүү боломжийг ашиглан үг зүй, өгүүлбэр зүй, үгийн сангийн аль боломжтой хувиргалыг хийж, санааг хурц тодорхой гаргахад чиглүүлэн орчуулсан байхад зарим орчуулгад ерөнхийдөө судрын хэлний үгчлэх зарчмыг голлон баримталсан судрын хэлний орчуулга ч бас байна.

Орчуулгын аргуудын үндсэн нэг бол үгчлэн орчуулах буюу кальк орчуулга юм. Энэ аргыг хэл шинжлэлд зээллэг орчуулга, үг үгээр орчуулах, үгчилсэн орчуулга, шууд орчуулга гэх мэт янз бүрээр нэрлэсэн нь байдаг. (Мөнхцэцэг, 2022, р. 123)

Монголчуудын төвөд хэлээр бүтээсэн ном судрын хэлний орчуулга бол бурхны номын үг үсэгт өчүүхэн ч гар хүрэхгүй гэдэг бишрэлийн үүднээс төвөд эхийн үг үсэг, бараг дагавар нөхцөлийг хүртэл хуулбарлан оноож, нэг ч үг үсгийг илүү дутуу хэрэглэдэггүй, хатуу дэг жаягтай орчуулга юм.

Тэгвэл “Хүмүүний номын баяр хурим” зохиолын бидний олж ажигласан олон орчуулгын хувьд төвөд эх, төвөд хэлний өгүүлбэрийн хэлбэр бүтцийн байдалд тодорхой хэмжээнд баригдсан шинжтэй, шүлгийн үг нэг бүрчлэн орчуулж, үгийн нэмэлт хасалт багатай шууд орчуулсан орчуулга дийлэнх нь байна. Тухайлбал, 6,7-р орчуулгуудаас бусад бүх орчуулгад уламжлалт үгчилсэн орчуулгын аргыг ашиглан дараах байдлаар орчуулжээ:

Tib: mi skya aug shud rgyan po'i sar mi phyin/_ / (80)

1-р орч. qar-a kümün šoo pai mörüi-yin yazar büü yabu

2-р орч. qara [qar-a] kümün čilayun naɣadam-tu [naɣadumtu] yazar büü oči

3-р орч. qar-a kümün šoi [šoo] pai mörügen [mörüyigen]- ü yazar ülü odmoi

4-р орч. qar-a kümün šo pai mörügen [mörüyigen]- ü qazar [yazar] ülü odmoi

5-р орч. qar-a kümün marɣuyan mörüicege talbiqu yazar büü yabu

8-р орч. qar-a kümün pai šo mörüyitü naɣadam-un yazar-tor büü od

9-р орч. egel kümün joɣus mörüicegekü yazar-tu büü oči

11-р орч. tomoɣatai kümün mörüyitü naɣadam-un yazar büü oči (Цогт, 2014, р. 2239)

12-р орч. har/_ hu ni/_ mu ri thi/_ na ka tam ma'ing/_ ka tsar/_ bu/_ o chi/ (15b)

13-р орч. qara kümün möretei nayadam-un yazar büü kürei (17a)

14-р орч. Харчуулын тоглоом наадам муруйны газар бүү оч гэж тус тус үгчлэн орчуулсан байна. mi skuа- хар хүн, эгэл хүн, томоотой хүн, харчуул гэж, rgyan po'i sa- мөрийний газар, наадамт газар, мөрийцөө тавих газар, мөрийт наадмын газар, наадмын газар зэрэг ижил утгатай үгсийг аль олноор хэрэглэж тухайн үгийн утга санааг нээж болохоор байна.

Иймд эдгээр орчуулга нь Агваандандар лхаарамбын “Хүмүүний номын баяр хурим” зохиолын төгсгөлийн үгэнд “...эдүгээ ч төвөд орны дохио доройтсон зарим энэ адилаг өөрийн хэлэндээ орчуулан мэдэх төдий гарваас төдий чинээ бурхны шашинд үйл үйлдсэн болох болой хэмээн дохио доройтсон буюу хуучин үг хэллэг зэрэг орчуулахад хүндрэлтэй үгсийг зохиолдоо нэгтгэн найруулсан тул өөрийн хэлэндээ орчуулж мэдэх болбол сайн” хэмээсэн зохиогчийн гол зорилготой нийцэж үгчлэн орчуулах арга нь бусад аргуудаас төвөд-монгол үгийг оноож мэдүүлэх, утгыг тайлахад чухал ач холбогдолтой байна.

3. Монгол ахуй шинжтэй холбон орчуулсан нь

Зарим орчуулгад нэр томъёо, үг илэрхийлэл, ойлголт ухагдахууныг орчуулахдаа хэт ягштал үгчлэлгүй, хэт чөлөөтэй утгачлалгүй, тэгсэн хэрнээ аль алийг алдалгүй тэгш барьж, аль болохоор хялбаршуулан орчуулах зарчмыг барьж, монгол ахуй сэтгэлгээндээ ойртуулан, уншигчдын таашаалд нийцүүлсэн, аль болох монгол хэлний үгийн санд зохицуулан орчуулжээ. Жишээ нь:

Tib: **sbre lbags** thul ba'i gon bajral na yang /_/_

de yi thu ba bcaд nas glan hi rigs/_/_ (77)

1-р орч. **kirsan-yin arasun** daqu-yin jaq-a qayarayсан-i-çu

tegün-ü qormui-yi tasulju nöкүкү johis ügei

10-р орч. **ünegen arisun** deçeng-un jagam-a ni ebderkü abçu

tegün-ü qarman-i qayičilaju abugad nöкүbel jokiqu ügei (Цогт, 2014, pp. 2226-2227)

12-р орч. **bi chi nu/_a ri san/_**tha ha ni+u/_ tsa ha ni/_ 'u rag ta san n' gi chu/

the gu ni/_ham tshu' gi ni/_tha sa lag sang /_ 'tshi nu hu hu gi tsho hi sa/_ 'u gus/ (15a)

Энд “sbre lbags” буюу “бичний арьс” гэдгийг 1-р орчуулгад “Хярсны арьсан”, 10-р орчуулгад “Үнэгэн арьсан” хэмээн орчуулсан байна. Монгол оронд бичний арьсаар дах хийж өмсөх явдал байхгүй ба харин хярс, үнэгний арьсаар хийж өмсдөг байсан тул ингэж орчуулсан байна.

4. Илт өгүүлэх нэрсийг орчуулсан нь

Монголчуудын төвөд үгийг монголоор оноон тохиолдуулахын гол зарчим болгон журамлан тогтоосон "Мэргэд гарахын орон" (Tib: dag yig mkhas pa'i 'byung gnas) нэрт дохионы бичгийн Барамидын аймагт “Бас зохист аялгууны учраа илт өгүүлэхийн нэрээр үзүүлсэн “илжгийг” “сайн хоолойт” хэмээсэн мэтийг ч мөнхүү тэр нэрээр орчуулан үйлдмүй. Өөрийн нэрээр үл орчуулах бүлгээ. Бусцар болбоос зохисгүй болохын тул болой” (Жанжааролбийдорж, 2021, р. 31) хэмээн айлджээ. Үүний талаар Төвөдөч эрдэмтэн Л.Хүрэлбаатар “Ёгтолж хэлсэн илт өгүүлэх нэрийн зүйлийг уг дүрслэлийн зүйлийг нь хэвээр хадгалах зорилгоор нуусан үгээр нь үзүүлэх” (1995, р. 82) хэмээн тэмдэглэсэн байна. Гэвч “Хүмүүний номын баяр хурим” зохиолын орчуулгуудад дараах байдалтайгаар нийтлэг орчуулсан нь ажиглагдаж байна. Үүнд:

Tib: **sa 'dzin khyogs 'degs chu gter** hub kyis 'dren/_/_
nyin mtshan mgon po cha lang brdab srid kyang /_/_

tsad ma'i skyes bus ma brtag gya tshob du/_/
don med bab col gzhar yang gsung mi srid/_/ (7)

7-р орч: Тухайлан **сүмбэр уулыг** жинлүүрдэн, **сүн далайг** оочин яндаж

Тунамал наран сарныг цан болгон дэлдэн байвч

Тун ч шалгадаг төрөлхтөн бүр анзаарга үгүй дэмий балайд

Тоймлох учир үгүй завхайг бяцхан ч хэзээ ч айлдах байхгүй (Хүрэлбаатар, Алтан хүрдэн, 1992, pp. 23-24)

12-р орч: Tib: **o' las** gi/_ cin bi ri/_ cig nyi hu/_ **ta las** gi/_ 'ou che bi ri/_ ta tha ho/

na ra/_ sa ra'i gi/_ tshang chi lin/_ til li se khu/_ bol pa cho/

lab tha kas/_ shal ka tag/_ thur leg then bi ri/_ shin gyil 'u gus/_ tsor ka' rang/

thou za/_ 'u gus/_ dzal che ya gi/_ khi gyi yi tu/_ dzar lig la cu/_ ul/_ bol tag

Мон: **Уулыг** жингээр жигнэх, **далайг** ойчихоор татах

Нар сарыг цанчилан дэлсэх боловч

Лавтай шалгадаг төрөлхтөн шинжилгүй зоргоороо

Тусгүй чалчааг хэзээд зарлиглаж үл болдог. (2b)

Үүнээс үзвэл sa 'dzin буюу газар баригч гэсэн илт өгүүлэх нэрийг уул, Сүмбэр уул гэж, chu gter буюу усан сан гэх илт өгүүлэх нэрийг Сүн далай, далай гэж, nyin mtshan mgon ро буюу өдөр, шөнийн итгэл гэх илт өгүүлэх нэрийг нар сар, тунамал наран саран гэж илт өгүүлэх нэрээр бус утгаар нь орчуулсан байна.

Энэ нь “Мэргэд гарахын орон” тогтсон даяг дахь илт өгүүлэх нэрийг ерийн нэрээр буулгавал ёгтолсон чимэг нь орчуулгад харагдахгүй болох тул үгчлэн буулгах зохистой хэмээсэн буй боловч дээрх орчуулга нь “Мэргэд гарахын орон”-д заасан орчуулгын мөрдлөгт харшилж байгаа ба уг эхийн илт өгүүлэх нэрийг ашигласан байдлыг харуулахгүй байх гэмтэй байна. Тиймээс

Шороог баригчийг¹ жингээр жигнэн, **усан санг**² ойчин татан

Өдөр, шөнийн итгэлийг³ цан болгон дэлдэх боловч

Шалгадаг төрөлхтөн⁴ бээр шинжлэл үгүй зоргоороо

Хэрэггүй чалчааг хэзээ ч айлдах нь үгүй. хэмээн илт өгүүлэх нэрсийг үгчилсэн орчуулгаар орчуулан ерийн нэрийг өлмийн зүүлтэд тодруулж өгвөл илт өгүүлэх нэрийн чимэг болон ерөнхий утга нь хүртэл харагдах болов уу хэмээн харж байна.

5. Хүндэтгэлийн үг, болон хуучин үгийг орчуулсан нь

Агваандандар лхаарамба "Хүмүүний номын баяр хурим" зохиолдоо судар номын хүндэтгэлийн үг болон хуучирсан үг хэллэгийг хэрхэн ашиглаж, түүнийг хожмын орчуулагчид хэрхэн ухаж ойлгож орчуулсныг жишээ татан үзүүлье. Төвөд эхэд:

Tib: **gna' dus** cho 'phrul ya ma zun bstan pas/_/

nyi tshe min pa'i 'gro mang 'dul bar mdzad/_/

da lta thub pa'i **zhal skyin** bshes gnyen pas/_/

dam chos 'o ma snyod pas **brtas par** mdzad/_/ (4)

1-р орч: **erte čay-dor** ridi qubilyan-i qoos üjegülügen

alayıci ügei olan amitan-i nomqatyan jokiyaju

edüge čidayci-yin **gegen-ü bey-e orulaqu** buyan sadun-iyar

degedü nom-un sün ögkü-ber **degjiyen** jokiya.

7-р орч: **Эрт урьдын цаг** рид хувилгааныг гүйцэд үзүүлснээр

¹ Ёгт нэр: Шороог баригч-уул

² Ёгт нэр: Усан сан-далай

³ Ёгт нэр: Өдөр, шөнийн итгэл- Нар, сар

⁴ Ёгт нэр: Шалгадаг төрөлхтөн-Бурхан

Идээр шидээр бус амьтан олныг номготгон айлдсан
Эдүгээ **бурхан бээр бодтой** буяны саднаар
Эрчимтэй дээдийн номын сүүнийг хөхүүлэн **төлжүүлэн** айлд

12-р орч:

Tib: **ir thu/_tsag thu/_yir thu/_ho bil kang 'ang/_'u ru su hil/_ho za'i gi/_'u tsu gu leg zang bre'i**
a har/_zhi hir/_bo sang'i/_a mi thang /_'o lan na gi/_nom kad han/_dzo khi yag chi
o ta/_bor han ni/_**or thu li sing tu/_bag shes/_sa tan bi ri/**
ti gi ting'i/_nom ma'ing/_su bi ri/_thi gyi yi gi seng bi ri/_**thul cu ku lin/_tso khi yag sang/**

Мон: **Эрт цагт** рид хувилгаан өрөөсгөл хосыг үзүүлснээр

Аахар шаахар бусын амьтан олныг номхотгон зохиогч

Одоо бурхны **ор төлөөсөнд** багш садан бээр

Дээдийн номын сүүгээр тэжээснээр **төлжүүлэн** зохиосон. Хэмээн тус тус орчуулжээ.

Эндээс төвөд хуучин үг хэллэг болох **gna' dus** буюу анхан, урд (tib: thog ma'm sngon) гэх утга бүхий үгийг дээрх орчуулгад эрт цагт, эрт урьд цаг гэх зэргээр орчуулсан байна. Мөн **brtas pa** буюу дэлгэрүүлэх, арвижуулах (Tib: rgyas pa) гэх утга бүхий үгийг төлжүүлэн, дэгжээн хэмээн өгүүлбэрт зохилдуулан орчуулсан байгааг ажиглаж болно.

Төвөд хэлээр **thub pa'i zhal skyin** буюу ялгуулсны орлогч (Tib: rgyal tsab) -ийн хүндэтгэлийн хэлбэрийг **бурхны ор төлөөсөн, бурхан бээр бодитой, чадагчийн гэгээний бие орлох** гэх зэрэг хүндэтгэлийн шинж чанар бүхий орчуулжээ.

5. Дүгнэлт

Алшаа Агваандандар лхаарамбын зохиол бүтээлийг өмнөх үеийн мэргэд монгол хэлэнд орчуулахад нэлээн төвөгтэй хэмээн үзэж байсан ба харин “Суртгаал хүмүүний номын баяр хурим”-ын олон орчуулга буй талаар олонтоо мэдээлжээ. 2014 онд Өвөр монголын эрдэмтэн Г.Цогт голлон найруулсан “Алшаа лхаарамба Агваандандарын зохиолын чуулган” хэмээх бүтээлийн зургаадугаар ботид “Суртгаал хүмүүний номын баяр хурим” зохиолын арван нэгэн орчуулгыг цуглуулан, эмхэтгэж гаргасан нь нэн чухал бүтээл болжээ. Үүнээс гадна бидэнд гурван орчуулга олдоод буйн дээр таван орчуулгын мэдээ бидэнд олдоод байна. Цаашид ч улам олон орчуулга нэмэгдэж болзошгүй.

“Суртгаал хүмүүний номын баяр хурим” зохиолын олон хувилбар орчуулга хадгалагдан ирсэн нь уг бүтээл монголын бичгийн соёл, орчуулгын уламжлалд өргөн дэлгэр тархаж, удаан хугацаанд идэвхтэй хэрэглэгдэж ирснийг харуулах ба уг бүтээлийн олон орчуулга зэрэгцэн оршиж буй гол шалтгаан нь Их хүрээний уламжлалт нэр орчуулгын хичээлд судалдаг байсны улбаа бололтой.

Эдгээр орчуулгыг харьцуулан үзэхэд бичиглэлийн хувьд монгол бичгээр уламжлагдсан, төвөд үсгээр монгол хэлийг галиглан тэмдэглэсэн зэрэг хэлбэрүүд зэрэгцэн оршин байгаа нь олон хэлбэрийн бичгийн уламжлал бидэнд дамжигдаж ирснийг нотолж байна. Энэ нь зөвхөн орчуулга төдийгүй хэл, бичгийн харилцан нөлөөллийн тод жишээ юм.

Орчуулгын аргын хувьд үгчилсэн болон утгачилсан (чөлөөт) орчуулгын зарчим зэрэгцэн хэрэглэгдсэн нь ажиглагдах бөгөөд ялангуяа шүлгийн хэлбэрт орчуулсан хувилбарууд нь эх зохиолын утгыг хадгалахын зэрэгцээ монгол хэлний яруу найргийн уламжлалд нийцүүлэх зорилготой байжээ. Харин зарим орчуулгад хүндэтгэлийн хэллэгийг онцгойлон хадгалсан нь Бурханы шашны бичвэрийн хэв шинж, соёлын онцлогийг орчуулгад тусгах оролдлого болохыг харуулна.

Цаашид эдгээр орчуулгуудыг бүрэн цуглуулж, харьцуулсан судалгаа хийх нь монголын орчуулгын уламжлал, төвөд-монгол хэлний харилцаа, Бурханы шашны сурвалжийн дамжуулалтын онцлогийг гүнзгийрүүлэн тодруулахад чухал ач холбогдолтой юм.

Comparative study of the Translation version of the “Fest of Human Rituals”, by Alasha Agwaandandar lharamba

Turmandakh Munkhbat¹  Erdenetuya Purevdorj*² 

¹Lecturer at the Department of Linguistics and Literature, Zanabazar Buddhist University of Mongolia; Ph.D. student, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

²Ph.D, Associate Professor, Department of Mongolian language, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

Abstract: The work “Surtgaal Khümüüni Nomin Bayar Khurim” (Tib: blsab bya mi chos dga’ ston zhes bya ba bzhugs so), composed by the renowned Mongolian scholar Alasha Agwaandandar lharamba, was originally written in Tibetan. It is considered one of the most difficult work to translate due to its distinctive Tibetan literary style, specialized terminology of Buddhist philosophy, use of explicit and figurative expressions, and the integration of colloquial, even harsh. Nevertheless, as this work has traditionally been studied within the curriculum of classical translation in Ikh Khüree, multiple translations have been preserved and transmitted, as noted by scholars. In this paper, we aimed to collect and compile these translations, systematize related information, and supplement existing data on certain versions. Additionally, we examined some of the orthographic and stylistic features of the identified translations. As a result, 14 translations were collected and documented, along with additional information on 5 more translations. Observations of these translations reveal several notable characteristics, including the transliteration of Mongolian words using Tibetan script, the application of Mongolian poetic alliteration techniques, the use of traditional literal translation methods, and the rendering of synonymy (tib: mngon brjod ming) and honorific terms. Further research is needed to gather additional data and sources on related translations and to conduct more comprehensive comparative analyses.

Keywords: Tibetan didactic literature, Alasha Agwaandandar lharamba, traditional translation, ten minor categories of translation, literal translation, alliteration

References

- Agvaanchoidor. (2009). *Alshaagiin Agvaandandar lkhaaramba “khümüünii nomyn bayar khurim”* [Agvaandandar Lkharamba of Alshaa: “The Feast of Human Ritual”]. Language, Script, Meaning and Culture: Academic Journal, No. 5(4).
- Ganbold, D. (2023). Tövd usgeer, mongol heeler bichsen gal takhilgyn negen sudar. [A Fire Offering Text Written in Mongolian Language Using Tibetan Script]
- Gombojav, D. (1961). *Mongolchuudyn түвд heeler zohioson zohiolyn zuil*. [Works Written by Mongolians in the Tibetan Language], Studia Mongolica, Tom I, Fasc. 4, 26-57
- Dolgorsuren, D. (2022). Mongol shülgiin hemjee hemnel, unshigdah “ayalguug” orchuulah ni /B.Yavuukhulangiin “Uulyn orgil” shülgiin angli orchuulgyn jisheen deer/ [Translating the Rhythm

- and “Melody” of Mongolian Poetry: Based on the English Translation of B. Yavuukhulan’s Poem “Mountain Peak”] Translation studies Vol. 10, 89-93 <https://doi.org/10.22353/TS20220112>
- Janjaarloibiidor, (2021) *Merged garakhyn oron nert togtooson dayag, [The Source of Wisdom]*, Ulaanbaatar. Bembi san press
- Munkhtsetseg, N.8 (2022). *Mongol khel sudlal, Kheregleenii hel shinjlel, hel bolovsruulalt, tügeemel khel zui [Mongolian language studies volume XV, Applied linguistics language processing universal grammar]* Ulaanbaatar. NUM Mongol sudlal khureelen press
- Sodnamdargia, D., (1978) *Agvaandandaryn zarim zohiol dahi philosophi logikiin uzel [Philosophical and Logical Views in Some Works of Agvaandandar]*, Ulaanbaatar
- Turmandakh, M., (2025). “*Khümüünii nomyn bayar hurimyn dohiony tailbar nyhsyn hüig nair*” zohiolyn bichver zuin sudalгаа. [*Textual Study of the Work "Decipher of Fest of Human Virtual-Celebration of Newborn"*], Tibet studies Tom. XIV, 129-141. <https://doi.org/10.5564/ts.v14i1.5289>
- Khurelbaatar, L., (1992). *Altan khürden [Golden Wheel]*, Ulaanbaatar, Tsog setguul press
- Khurelbaatar, L., (1995). *Mongol orchuulgyn товчоон [A Brief History of Mongolian Translation]*, Ulaanbaatar, Ulsyn hevlelyn gazar press
- Khurelbaatar, L., (2002). *Sudar shastiryin bilig [Wisdom of Sutras and Treatises]*, Ulaanbaatar,
- Tsogt, G., *Alshaa lkhaaramba Agvaandandaryn zohiolyn chuulgan /zurgaadugaar bothi/, /Hümüünii nomyn bayar khurim khemeekh surgaal shülgiin orchuulgyn kharitsuulal. [Collected Works of Alshaa Lkharamba Agvaandandar, Volume VI: A Comparative Study of the Translation of the Didactic Poem “The Feast of Human Ritual” Üvür mongolyn khebleliin buleglel, Üvür mongolyn soyolyn khebleliin khoroo press*